

Байнгын хорооны хуралдааны тэмдэглэл
2025 ОНЫ 01 ДҮГЭЭР САРЫН 23-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН 2024 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2025 ОНЫ 01 ДҮГЭЭР САРЫН 23-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААН

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА
2025 оны 01 дүгээр сарын 23-ны өдөр Пүрэв гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга	1
Хуралдааны товч тэмдэглэл:	2-7
Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	8-14

1.Шинэ зуун мод хотын эрх зүйн байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2025.01.22-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/	8-14
---	------

**Монгол Улсын Их Хурлын 2024 оны намрын ээлжит чуулганы
Төрийн байгуулалтын байнгын хорооны 2025 оны
01 дүгээр сарын 23-ны өдөр /Пүрэв гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл**

Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга Ж.Бат-Эрдэнэ ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 25 гишүүнээс 13 гишүүн хүрэлцэн ирж, 52.0 хувийн ирцтэйгээр хуралдаан 13 цаг 00 минутад Төрийн ордны “Үндсэн хууль” танхимд эхлэв.

Томилолттой: Т.Доржханд, Ц.Сандаг-Очир;
Чөлөөтэй: С.Амарсайхан, О.Алтангэрэл, Э.Болормаа, Ж.Баярмаа,
Г.Уянгахишиг, Л.Оюун-Эрдэнэ, О.Цогтгэрэл, Л.Энх-Амгалан;
Эмнэлгийн чөлөөтэй: Л.Гантөмөр.

Нэг.Шинэ зуун мод хотын эрх зүйн байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2025.01.22-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайд Ж.Батсуурь, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч Х.Нямбаатар, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хууль тогтоомж, гэрээ, эрх зүйн газрын дарга М.Үнэнбат, Шинэ Зуунмод хотын Захирагчийн чиг үүргийг хэрэгжүүлэх хотын бүтээн байгуулалт, хөгжлийн асуудал хариуцсан бүрэн эрхт төлөөлөгч М.Батбаяр, газрын Хэрэг эрхлэх газрын Хууль, эрх зүйн газрын дарга Д.Саруул, мөн Засгийн газрын референт Д.Нямдэлгэр, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны Хот байгуулалтын бодлого, зохицуулалтын газрын дарга Ц.Баярбат, Шинжлэх ухааны академийн дэд ерөнхийлөгч Ц.Цэрэндорж, Шадар сайдын Ажлын албаны дарга бөгөөд ахлах зөвлөх Б.Мөнх-Оргил нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх Д.Нямбаяр, Байнгын хороодын ажлын албаны дарга бөгөөд Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Хатантуул, мөн албаны референт Э.Баттогтох нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаарх илтгэлийг Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайд Ж.Батсуурь танилцуулав.

Илтгэлтэй холбогдуулан Байнгын хорооны дарга Ж.Бат-Эрдэнийн тавьсан асуултад Шинжлэх ухааны академийн дэд ерөнхийлөгч Ц.Цэрэндорж хариулж, тайлбар хийв.

Ж.Бат-Эрдэнэ: 1.Шинэ Зуунмод хотын эрх зүйн байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 7
Бүгд: 13
46.2 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Ө.Шижирийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Ж.Бат-Эрдэнэ: Улсын Их Хурлын гишүүн Ө.Шижирийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 6
Бүгд: 13
53.8 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Ж.Бат-Эрдэнэ: 1.Шинэ Зуунмод хотын эрх зүйн байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 6
Бүгд: 13
53.8 хувийн саналаар дэмжигдлээ.

Хамт өргөн мэдүүлсэн:

Ж.Бат-Эрдэнэ: 2.Шинэ Зуунмод хотын эрх зүйн байдлын тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 6
Бүгд: 13

53.8 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Хөрөнгө оруулалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 6
Бүгд: 13

53.8 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 7
Бүгд: 13

46.2 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Ж.Бат-Эрдэнэ: Горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 6
Бүгд: 13

53.8 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

4.Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 6
Бүгд: 13

53.8 хувийн саналаар дэмжигдлээ.

5.“Тогтоолд өөрчлөлт оруулах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 6
Бүгд: 13

53.8 хувийн саналаар дэмжигдлээ.

6.“Тогтоолд өөрчлөлт оруулах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 6
Бүгд: 13

53.8 хувийн саналаар дэмжигдлээ.

7.“Тогтоолд өөрчлөлт оруулах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 6
Бүгд: 13

53.8 хувийн саналаар дэмжигдлээ.

8.“Тогтоолд өөрчлөлт оруулах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 6
Бүгд: 13

53.8 хувийн саналаар дэмжигдлээ.

9.“Тогтоолд өөрчлөлт оруулах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 7
Бүгд: 13

46.2 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Ц.Тувааны “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Ж.Бат-Эрдэнэ: Улсын Их Хурлын гишүүн Ц.Тувааны гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 6
Бүгд: 13

53.8 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

9. “Тогтоолд өөрчлөлт оруулах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 5
Бүгд: 13
61.5 хувийн саналаар дэмжигдлээ.

10. “Тогтоолд өөрчлөлт оруулах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 6
Бүгд: 13
53.8 хувийн саналаар дэмжигдлээ.

11. “Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 7
Бүгд: 13
46.2 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Ж.Бат-Эрдэнэ: Горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 6
Бүгд: 13
53.8 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

11. “Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 6

Бүгд: 13
53.8 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн С.Бямбацогт Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Байнгын хорооны хуралдаанаар 1 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 25 минут үргэлжилж, 25 гишүүнээс 14 гишүүн хүрэлцэн ирж, 56.0 хувийн ирцтэйгээр 13 цаг 25 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА

Ж.БАТ-ЭРДЭНЭ

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ
ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ

П.МЯДАГМАА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ
2025 оны 01 дүгээр сарын 23-ны өдөр,
Пүрэв гараг Төрийн ордон “Үндсэн хууль” танхим 10 цаг 30 минут

**ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ**

Ж.Бат-Эрдэнэ: Төрийн байгуулалтын байнгын хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирж, ирц бүрдсэн тул 2025 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн хуралдааныг нээснийг мэдэгдье ээ.

Ирцийг танилцуулъя. Дашзэвэгийн Амарбаясгалан дарга ирсэн байна, Баярмагнайн Баярбаатар гишүүн ирсэн, Лхагвын Мөнхбаатар гишүүн ирсэн, Эрдэнэбилигийн Одбаяр гишүүн ирсэн, Өлзийхүүгийн Шижир гишүүн ирсэн, Жадамбын Бат-Эрдэнэ ирсэн, Сандагийн Бямбацогт гишүүн ирсэн, Одсүрэнгийн Номинчимэг гишүүн ирсэн, Цэвэгдоржийн Туваан гишүүн ирсэн, Батын Батбаатар гишүүн ирсэн, Сархадын Зулпхар гишүүн ирсэн, Нямтайширын Номтойбаяр гишүүн ирсэн, Ням-Осорын Учрал гишүүн ирсэн байна аа.

Ингээд Байнгын хорооны 2025 оны 1 сарын 23-ны өдрийн хуралдааныг нээе. Хуралдаанд нэг асуудлыг танилцуулъя.

Шинэ Зуунмод хотын эрх зүйн байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд Засгийн газар 2025 оны 1 сарын 22-ны өдөр өргөн мэдүүлсэн хэлэлцэх эсэх.

Хэлэлцэх асуудал дээр саналтай гишүүд байна уу? Нэрсээ өгье. Алга байна.

Ингээд хууль санаачлагчийн илтгэлийг Монгол Улсын сайд Батсуурь сайд танилцуулна аа.

Батсуурь сайдын микрофоныг. Ажлын хэсгийн 4 номерын микрофон.

Ж.Батсуурь: Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлаас 2024 оны 6 дугаар сарын 5-ны өдөр Шинэ Зуунмод хотын эрх зүйн байдлын тухай хуулийг баталж мөн өдрийн хот байгуулах тухай Улсын Их Хурлын 76 дугаар тогтоолоор шинэ Зуунмод хотыг байгуулж нийслэлийн Тусгай чиг үүргийг гүйцэтгэхэд Стратегийн ач холбогдол бүхий Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын дагуул хот байхаар заасан юм аа. Шинэ Зуунмод хот нь хуулиар тусгайлан тогтоосон чиг үүрэг, удирдлага, зохион байгуулалт, эдийн засагтай нийслэлийн хотын тусгай чиг үүргийг буюу Төв аймагтаа бүх талаар хөгжлийн интеграцад орж хотын эдийн засгийн үр ашгийг хамт бүрдүүлэх үүрэгтэй юм. Хотын бүтээн байгуулалтыг хэрэгжүүлэхэд тус төслийг олон улсын түвшинд сонирхолтой хөрөнгө оруулалтыг татах тохиромжтой нөхцөлөөр танилцуулах цаашид дэлхийд танигдсан хот болгон хөгжүүлэхэд хотын нэр чухал үүрэгтэй гэж үзэж байгаа юм аа.

Гэтэл Зуунмод хот гэх нэршил нь Төв аймаг буюу Зуунмод хотын дагуул хот эсвэл Зуунмод хотыг шинэчлэн зохион байгуулах төлөвлөлт гэсэн нь зөрүү ойлголтыг төрүүлж байна. Олон улсын туршлагаас үзэхэд хотын нэрийг олон улсад тухайн улс орны талаарх төсөөллийг бий болгох соёлын өв, түүхийг онцолсон төдийгүй олон улсын санхүү, бизнес, аялал жуулчлалын төв, ухаалаг хот байх нөхцөлийг илэрхийлж чадахуйц олон улсад дуудах бичихэд хялбар ойлгомжтой байдлаар тогтоох нь цаашид маркетинг сурталчилгааны стратегийг өргөн хүрээнд төлөвлөх боломжийг бүрдүүлдэг юм байна аа.

Өөрөөр хэлбэл хотын оноосон нэр нь тус бүтээн байгуулалт улс орны хөгжил төдийгүй олон улсын хэмжээнд ямар хүн оруулахыг тодорхойлсон түүх, соёл, байгаль орчин, эдийн засгийн чадамж гэх мэт бусдаас ялгаруулах онцлог болон хотын хөгжлийн зорилго ирээдүйн байр суурийг бүрэн илэрхийлснээр олон улсын хөрөнгө оруулагчдыг татах түншлэл дэмжлэгийг нэмэгдүүлэхэд нөлөөлдөг байна аа.

Монголчууд эртнээс төрт ёсны түүхтэй Евроази төдийгүй дэлхий дахинд нэр алдар нь түгсэн эзэнт гүрнүүдийн өлгий нутаг бөгөөд Евроазийн хээр талд нүүдлийн иргэншил давамгайлсан хөгжсөнөөр Хүннү нар Төв Азийн тал нутагт төрийн зохион байгуулалттай хүчирхэг нүүдэлчдийн төрт улсыг үүсгэн олон улсын худалдаа, Торгоны замыг хяналтдаа авч Евро Азийн түүхэнд гүнзгий ул мөр үлдээсэн байдаг байна аа. Тиймээс Монгол Улсын талаар төдийгүй шинэ хотын төлөвлөлт, бүтээн байгуулалт, төслийн зорилтын байдлаар илэрхийлэх зорилгоор Шинэ Зуунмод хотыг Хүннү хот гэж нэрлэн Монгол Улсынхаа төрт ёс, түүх, уламжлал, соёлыг олон улсад илэрхийлэн таниулах цаашлаад олон улсын чиг хандлагад нийцсэн ухаалаг хот болгон хөгжүүлэх зорилгоор уг хуулийн төслийг боловсруулсан.

Алсын хараа 2050 урт хугацааны бодлогын баримт бичигт энэхүү хотыг Хөшигийн хөндийд байгуулагдсан Чингис хаан олон улсын нисэх буудлийг түшиглэн Монгол Улсын тээвэр, ложистикийн гол төв байхаар төлөвлөж цаашид Зүүн Хойд Азийн зорчигч агаарын тээврийн нэгдсэн зангилаа төв болгон хөгжүүлэх зорилтыг дэвшүүлж байгаа юм.

Энэхүү дагуул хот байгуулагдсанаар Улаанбаатар хотын төвлөрөл тодорхой хувиар буурахаас гадна Богд Хаан төмөр зам, чөлөөт бүс, тээвэр ложистикийн төв болж Монгол Улсын эдийн засгийн өсөлтийг 10-аас 15 хувиар тэлэх боломжтой гэж үзэж байгаа юм. Энэ хотод төр захиргааны байгууллагуудын нэгдсэн цогцолбор байрлах бөгөөд олон улсын нисэх буудлийг түшиглэн олон улсын дээд хэмжээний уулзалт арга хэмжээг зохион байгуулах цогцолбор байгуулж үйлчилгээний менежмент аюулгүй байдлыг хангах тогтолцоог бий болгоно оо.

Иймд дээрх зорилтод нийцсэн, амьдрахад таатай, байгаль орчинд ээлтэй, хүн төвтэй ухаалаг хот болгон хөгжүүлэх зорилго олон улсын чиг хандлагыг харгалзан шинэ Зуунмод хотыг Хүннү хот гэж нэрлэх нь уламжлал шинэчлэлийг хослуулан томъёолол хэмээн тодорхойлж байна. Хүннү хот болсноор Хүннү улсыг англиар Шинью гэж дууддаг гаралтайгаас бичигдэн Шинью эмпир гэж бичдэг байдлыг өөрчлөн хүннү гэх Монгол дуудлагыг таниулах, хоногшуулах хүннү эмпир бичлийг олон улсад хэвшүүлэх хэрэгцээг харгалзан үзсэн болно.

Хүннү хот нь Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын дагуул хотын хувьд нийт хүн амын дийлэнх хэсгийн амьдрах оршин суух нөхцөлийг бүрдүүлэх Улаанбаатар хотод ирж байгаа ачаалал төвлөрлийг задалж, суурьшлийг тэнцвэржүүлэх, зам тээвэр ложистикийн үйлчилгээ, дэд бүтцийн хангамж, хүртээмжийг нэмэгдүүлэх замаар эдийн

засгийн бие даасан байдлыг хангах, байгаль орчинд ээлтэй, хүний аюулгүй байдал, амгалан амьдрах боломжийг бүрдүүлсэн тогтвортой хөгжлийн загварыг бий болгох буюу улс орны эдийн засгийн аюулгүй байдлыг хангахад чиглэнэ ээ.

Шинэ Зуунмод хотын эрх зүйн байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон дагалдах хууль тогтоомжийн төслийг боловсруулан Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 33.1-д заасны дагуу яаралтай хэлэлцүүлэхээр өргөн мэдүүлсэн болно.

Хуулийн төслийг хэлэлцэн дэмжиж өгөхийг та бүхнээс хүсье ээ.

Баярлалаа.

Ж.Бат-Эрдэнэ: Ажлын хэсгийг танилцуулъя.

Цэрэндорж ШУА-ийн дэд ерөнхийлөгч Цэрэндорж, Д.Саруул ЗГХЭГ-ын Хууль эрх зүйн газрын дарга, Д.Нямдэлгэр ЗГХЭГ-ын референт, Ц.Баярбат Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны Хот байгуулалтын бодлого зохицуулалтын газрын дарга, М.Үнэнбат НЗДТГ-ын Хууль тогтоомж, гэрээ, эрх зүйн газрын дарга, М.Батбаяр Шинэ Зуунмод хотын Захирагчийн чиг үүргийг хэрэгжүүлэгч Хотын бүтээн байгуулалт хөгжлийн асуудал хариуцсан бүрэн эрхт төлөөлөгч ирсэн байна аа. Ингээд хууль санаачлагчийн илтгэл, төслийн үзэл баримтлалтай холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу? Нэрсээ өгнө үү? Алга байна.

Нэг асуулт байгаа юм байна шүү. Цэрэндорж Дэд ерөнхийлөгчөөс. Хүннү гэдэг нэрээ ер нь та хэд яаж харж байгаа юм? Нэгдүгээрт бол нэрнийхээ дуудлагыг өөрчилье гэж байгаа юм байна шүү дээ. Олон улсад явдаг хэллэг галиглалыг нь өөрчилье гэж байгаа юм байна.

Хоёрдугаарт ач холбогдлоо яг юу гэж байгаа вэ юу гэж харж байгаа вэ? Тэрийг нэг тодруулж өгөөч? 6 номерын микрофон.

Ц.Цэрэндорж: Баярлалаа. Хүннү гэдэг нэрийн дуудлагыг өөрчилж байгаа асуудал биш. Энэ ер нь 2 мянга гаран жилийн өмнө тухайн үеийн тэр Хүннү гэдэг улсын нэрийг Хятадад юу гэж тэмдэглэж байсан гэдгийг цэгцэлж байгаа асуудал л даа. Тэгэхээр яах вэ яг тухайн үеийн Хятад хэлний дуудлага одоогийн дуудлага 2 бол өөр, хувирч өөрчлөгдсөн байдаг. Тэгээд судлаачид тухайн үед бол ер нь хүнн но юм уу эсвэл хүнн на гэж нэрлэж байсан гэдгийг таамаглан сэргээсэн байгаа. Гэвч эрдэм шинжилгээний хүрээнд яг одоогийн Хятад дуудлагыг англиар галиглаад Сён Ну гэж бичээд байдаг.

Тийм учраас энэ нэг Хятад нэр шиг ингэж харагдаж байгаа. Одоо бид нар бол яг харьцангуй өөрсдийнх нь уугуул дуудлагад нь дөхүүлээд Хүннү гэж нэрлээд тэгээд түүнийгээ латин галигаар бичиж хэвшүүлэх энэ асуудлыг голлон тавьж байгаа юм аа.

Хоёрдугаарт энэ яг ач холбогдол нь юу вэ гэдэг дээр бол Хүннү бол Монголын анхны төрт улс, 2011 оноос хойш бид нар наадмаар Хүннү гүрний тэдэн жилийн ой гэж ингэж зарлаж явж байгаа.

Тийм учраас тэр улсаа Хүннүгийн талаар жишээлбэл өөр улсууд өөрийнхөө улсын түүхтэй холбох явдал байдаг. Тийм учраас бид нар аль болох Хүннү бол Монголчууд юм. Монголчуудын анхны төр улс юм гэдэг энэ талыг нь илүү онцолж түүнийг нь дэлхий даяар

бас энэ хотын нэрээрээ дамжуулж таниулах, сурталчлах бататгаж авах энэ бодлын үүднээс ийм нэрийг санал болгож байгаа юм аа. Баярлалаа. Хүннү гэдэг маань утга илэрхийлж байгаа билүү? 6 номер

Ж.Бат-Эрдэнэ: Хүннү гэдэг маань утга илэрхийлж байгаа билүү? 6 номер.

Ц.Цэрэндорж: Хүннү гэдэг бол яг судлаачдын дунд тийм утгатай үг гэсэн баттай тогтоосон зүйл одоогоор байхгүй байгаа. Зүгээр гадаад үгийг тухайн үед Хятадууд тэмдэглэхдээ ханз үсгээр тэмдэглэдэг. Одоо ч ялгаагүй. Тэгэхээр энэ ханз үсгээр тэмдэглэхдээ энэ Сүн Нү гэдэг 2 ханз бол жоохон тийм бүдүүлэгдүү тиймэрхүү боол эд нар гэсэн утгатай. Тэгэхээр бид нар бол энэ ханзны утгад ач холбогдол өгөх биш уугуул энэ Хүннү гэдэг нэр энийгээ сэргээх үүнийгээ хэвшүүлэх л чухал байгаа юм.

Баярлалаа.

Ж.Бат-Эрдэнэ: Гишүүд асуулт асуучихлаа. Үг хэлэх гишүүд байна уу? Алга байна. Гишүүд асуулт асууж, үг хэлж дууслаа.

Ингээд санал хураалт. Хэдэн саналтай байна. Нэлээн хэдэн санал байгаа юм байна шүү.

Санал хураалт явуулъя. Эхний санал хураалт.

Шинэ Зуунмод хотын эрх зүйн байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжих нь зүйтэй гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалт^

25 гишүүнээс 13 гишүүн нь дэмжиж 52 хувиар санал дэмжигдлээ.

Шижир их ороогүй байна. Шижир гишүүн санал гаргаж байгаа юм уу? Шижир гишүүн.

Ө.Шижир: Байнгын хороон дарга аа миний төхөөрөмж сая үнэхээр болсонгүй. 2 ч удаа уншуулаад. Тэгэхээр саяын саналыг хүчингүй болгоод дахин санал хураалт явуулж өгнө үү?

Ж.Бат-Эрдэнэ: Шижир гишүүний гаргасан санал хураалтыг хүчингүй болгоё гэсэн саналын томъёололоор санал хураалт явуулъя.

Санал хураалт.

13 гишүүнээс 7 гишүүн дэмжиж, 53.8 хувиар санал дэмжигдлээ.

Дахин санал хураалт явуулъя. Санал хураалт.

13 гишүүнээс 7 гишүүн дэмжиж 53.8 хувиар санал дэмжигдлээ

2.Шинэ Зуунмод хотын эрх зүйн байдлын тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжих нь зүйтэй гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалт.

13 гишүүнээс 7 гишүүн дэмжиж, 53.8 хувиар санал дэмжигдлээ.

3.Хөрөнгө оруулалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжих нь зүйтэй гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалт.

13 гишүүнээс 7 гишүүн дэмжиж, 53.8 хувиар санал дэмжигдлээ.

4.Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжих нь зүйтэй гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалт.

Миний төхөөрөмж ажилласангүй санал хураалтыг хүчингүй болгоё гэсэн саналыг гаргаж байна аа.

Тэгээд санал хураалтыг дахин явуулъя юу? Хүчингүй болгоё гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя аа.

Санал хураалт.

53.8 хувиар санал дэмжигдлээ.

Дахиад санал хураалт явуулъя.

Санал хураалт.

13 гишүүнээс 7 гишүүн дэмжиж 53.8 хувиар санал дэмжигдлээ.

5.“Тогтоолд өөрчлөлт оруулах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжих нь зүйтэй гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалт.

13 гишүүнээс 7 гишүүн дэмжиж, 53.8 хувиар санал дэмжигдлээ.

6.“Тогтоолд өөрчлөлт оруулах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжих нь зүйтэй гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалт.

13-аас 7 гишүүн дэмжиж, 53.8 хувиар санал дэмжигдлээ.

7.“Тогтоолд өөрчлөлт оруулах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг үзэл байдлын хүрээнд дэмжих нь зүйтэй гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалт.

13-аас 7 гишүүн дэмжиж, 53.8 хувиар санал дэмжигдлээ.

8.“Тогтоолд өөрчлөлт оруулах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд нь дэмжих нь зүйтэй гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалт.

13 гишүүнээс 7 гишүүн дэмжиж, 53.8 хувиар санал дэмжигдлээ.

9.“Тогтоолд өөрчлөлт оруулах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжих нь зүйтэй гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалт.

Миний төхөөрөмж болсонгүй ээ. Тийм болохоор дахин санал хураалтыг хүчингүй болгоё гэсэн санал гаргаж байна аа. Ингээд санал хураалтыг хүчин болгоё гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалт.

Туваан сайд. Туваан гишүүн.

Ц.Туваан: Төхөөрөмж ажилласангүй ээ. Санал хураалтыг хүчингүй болгож дахин санал хураалт хийж өгнө үү.

Ж.Бат-Эрдэнэ: Туваан гишүүний гаргасан саналын дагуу санал хураалтыг хүчингүй болгоё гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалт.

13-аас 7 гишүүн дэмжиж 53.8 хувиар санал хүчингүй боллоо.

Санал хураалтыг дахин явуулъя.

Санал хураалт.

13-аас 8 гишүүн дэмжиж 61.5 хувиар санал дэмжигдлээ.

10.“Тогтоолд өөрчлөлт оруулах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжих нь зүйтэй гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалт.

13 гишүүнээс 7 гишүүн дэмжиж, 53.8 хувиар санал дэмжигдлээ.

11. “Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжих нь зүйтэй гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалт.

Минийх орсонгүй тул санал хураалтыг хүчингүй болгоё гэсэн санал гаргаж байна аа. Тийм болохоор санал хураалтыг хүчингүй болгоё гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалт.

7-гоос 13-аас 7 гишүүн дэмжиж, 53.8 хувиар санал дэмжигдлээ.

Санал хураалтыг хүчингүй болгоё гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулж дэмжигдсэн тул дараагийн санал хураалтыг явуулъя.

Санал хураалт.

13 гишүүнээс 7 гишүүн дэмжиж, 53.8 хувиар санал дэмжигдлээ.

Шинэ Зуунмод хотын эрх зүйн байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг хийж дууслаа.

Байнгын хорооны санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Бямбацогт гишүүн танилцуулна.

Төрийн байгуулалтын байнгын хорооны хэлэлцэх асуудал дууссан тул өнөөдрийн хуралдааныг өндөрлөснийг мэдэгдье ээ. Баярлалаа гишүүддээ.

13.25 цагт

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ
ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ, ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ

П.МЯДАГМАА